

**БАТЛАВ:**

**УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН**

**Б.БАТТӨМӨР**

**БАНКНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙГ  
ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ  
ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

**Нэг. Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага:**

Улсын Их Хурлаас 2021 онд баталсан Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулиар банкнийг нээлттэй болон хаалттай хувьцаат компанийн хэлбэрээр зохион байгуулах, банкны хувьцаа эзэмшигчдийн төвлөрлийг бууруулах зэрэг зохицуулалтыг оруулсан. Уг зохицуулалтын хүрээнд банкны системд нөлөө бүхий банкнийг нээлттэй хувьцаат компани хэлбэрээр өөрчлөн байгуулах шаардлагыг тогтоосон бөгөөд үүний дагуу Хаан банк, Худалдаа хөгжлийн банк, Голомт банк, Хас банк, Төрийн банк анх удаа хувьцаагаа олон нийтэд санал болгон хөрөнгийн зах зээл дээр амжилттай гаргаж, банкны салбарын хувьцаа эзэмшигчдийн төвлөрлийн хэмжээ тодорхой хэмжээгээр буурч, банк санхүүгийн салбар 70 мянга гаруй хувьцаа эзэмшигчидтэй боллоо.

Улсын Их Хурлаас 2021 онд баталсан Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн дагуу банкны системд нөлөө бүхий банкууд 5.0-11.6 хувийн хувьцааг, Богд банк 20.0 хувийн хувьцааг 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдөрт багтаан олон нийтэд арилжиж, нээлттэй хувьцаат компанийн хэлбэрт шилжсэн. Хэдийгээр банк хуульд заасан хугацаанд компанийн хэлбэрээ өөрчилсөн боловч банкны хувьцаа эзэмшлийн төвлөрлийг бууруулах хуулийн шаардлагын хэрэгжилтэд гадаад, дотоод нөхцөл байдлын улмаас хүндрэлүүд бий болсон. Тухайлбал, банкны салбарын шинэтгэлийн хөтөлбөрийн хэрэгжилтийн талаарх банкуудын тайланд банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн төвлөрлийг бууруулах арга хэмжээ нь олон улсын хөрөнгийн зах зээл, боломжит хөрөнгө оруулагчдаас хамааралтай байгаа ба хувь нийлүүлсэн хөрөнгийн хувьцаа эзэмшигчдийн төвлөрлийг нэгэн зэрэг богино хугацаанд бууруулах нь боломжит цөөн тооны хөрөнгө оруулагчдад болгоомжлол үүсгэх, шийдвэр гаргалтад нөлөөлөх, улмаар эх үүсвэрээ хумих зэргээр банкны салбарын тогтвортой байдалд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байна.

Мөн дээрх Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн шаардлага мөрдөгдөж эхэлсэн даруйд Ковид-19 цар тахлаас шалтгаалан тогтоосон тодорхой хязгаарлалт, ердийн үйл ажиллагааны идэвхжил суларснаас банкнуудаас шинэ хөрөнгө оруулалт эрэлхийлэх боломж харьцангуй хязгаарлагдмал байсан, Монголын хөрөнгийн захын өнөөгийн нөөц багтаамж болон гадаад хөрөнгө оруулалтын татварын хэмжээ өндөр, Төв банкны бодлогын хүү өндөр зэрэг хөрөнгө оруулалтын орчин таатай бус байгааг харгалзан үзэхэд банкуудын хувьцаа эзэмшлийн төвлөрлийг дийлэнх банкнуудаас богино хугацаанд багтаан бууруулах боломж хязгаарлагдмал байна.

**Хоёр.Хуулийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ:**

Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.17 дахь заалтад зааснаар боловсруулна. Энэхүү хуулийн төсөлд банкны салбарт үзүүлсэн коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахал болон Монголын хөрөнгийн захын өнөөгийн нөөц багтаамж болон гадаад хөрөнгө оруулалтын татварын хэмжээ өндөр, Төв банкны бодлогын хүү өндөр зэрэг хөрөнгө оруулалтын орчин таатай бус байгаа зэрэг нөлөөллийг судалж банкны хувьцаа эзэмшлийн төвлөрлийг бууруулахтай холбогдсон хуулийн хугацааг 2026 оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуустал хугацаагаар сунгахаар тусгана.

**Гурав.Хууль батлагдсаны дараа үүсч болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх арга хэмжээний санал**

Хууль батлагдсанаар банкны хувьцаа эзэмшлийн төвлөрлийг аажмаар бууруулах, банк, санхүүгийн салбарын тогтвортой байдал, засаглал болон хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх ач холбогдолтой бөгөөд банкны хувьцаа эзэмшлийн төвлөрөл бодитоор, үе шаттайгаар буурч олон нийтийн хяналт, оролцоо бүхий банкны орчин бүрдэнэ гэж үзэж байна.

**Дөрөв.Нэмэлт, өөрчлөлтийн хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, түүнийг хэрэгжүүлэх зорилгоор цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах талаарх санал**

Хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулах хуулийн төсөл байхгүй болно.

**ХУУЛЬ САНААЧЛАГЧ**